



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
М.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: (976-51) 26 20 46, Факс: (976) 7015 2046,  
Цахим шуудан: info@ags.gov.mn,  
Цахим хуудас: www.ags.gov.mn

2024.08.29 № 01/620

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тайлан, зөвлөмж хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу танай аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмжийг хавсралтаар хүргүүлж байна.

Дээрх журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба хуралдааны тэмдэлэлээр өгсөн үүрэг, тайланд тусгасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллана уу.

Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлийг хавсаргав.

Хавсралт: 13 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.БАТХУЯГ



15160 0 2853



Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх  
газрын 2024 оны ... дугаар сарын  
... өдрийн ... дугаар албан бичгийн  
хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАР**

9023010230 CTC3950 6975747

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023  
ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР, 2024

## АГУУЛГА

НЭГ. ЗОРИЛГО .....	2
ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ.....	2
ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ .....	2
3.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ .....	2
3.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ.....	3
3.4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ ....	3
3.5.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ.....	5
3.6.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ.....	6
ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ.....	6
4.1 Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн үнэлгээ. ....	6
4.2 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт .....	6
4.3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ.....	7
ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ .....	8
5.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ.....	8
5.2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ .....	8
5.3.Шударга байдлын түвшний үнэлгээ.....	9
ЗУРГАА. ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ.....	9
6.1.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ.....	9
ДОЛОО. ДҮГНЭЛТ .....	9
НАЙМ. ЗӨВЛӨМЖ.....	10



# **ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

## **НЭГ. ЗОРИЛГО**

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг хянах, үнэлэх, дүгнэлт зөвлөмж гаргах, цаашид шийдвэр гаргах түвшинд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, бодлого, үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналыг сайжруулж, улмаар түүний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэхэд оршино.

## **ХОЁР. ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” (цаашид “нийтлэг журам” гэх), Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримтлан Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Бодлогын баримт бичиг болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дээрх журмын 6.2.1-д зааснаар хувиар илэрхийлэн үнэлсэн, харин тоо, чанараар илэрхийлэх боломжгүй зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг мөн журмын 6.2.2-т заасан аргачлалаар, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын ил тод байдлыг хангах үйл ажиллагааг дээрх журмын 6.3-д заасан аргачлалаар тус тус үнэлэв.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 9.7, 9.8-д заасны дагуу Шударга байдлын түвшний үнэлгээг Авлигатай тэмцэх газрын, шилэн дансны хөтлөлтийг Сангийн яамны үнэлгээний дүнг тус тус үндэслэн үнэлгээнд оруулан тооцов.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тус аймгаас цаасан болон цахим хэлбэрээр ирүүлсэн тайланд тулгуурласны зэрэгцээ бусад холбогдох баримт бичиг, статистик мэдээлэлтэй зохих харьцуулалт хийж, 2023 онд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг харгалзан үзсэн болно.

## **ГУРАВ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

### **3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн үнэлгээ**

Монгол Улсын хууль, Монгол Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын тогтоол зэрэг нийт 9 баримт бичигт Орхон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 114 шийдвэрийн 177 заалтын биелэлтийг хянан үзэж, 86.1 хувиар үнэлэв. Энэ нь өмнөх оны үнэлгээнээс 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээ

Эрх зүйн актын төрөл	Заалтын тоо	Үнэлгээ (заалтын тоогоор)				Үнэлгээний дундаж %/
		Бүрэн хэрэгжсэн 100.0	Хэрэгжих шатанд 70.0	Хэрэгжилт хангалтгүй 30.0	Хэрэгжээгүй 0.0	
1. Монгол Улсын хууль	21	16	4	-	1	89.5
2. УИХ-ын тогтоол	10	3	5	2	-	71.0
3. УИХБХ-ны тогтоол	38	16	19	2	1	78.7
4. Ерөнхийлөгчийн зарлиг	10	10	-	-	-	100.0
5.1. ҮАБЗ-ийн тэмдэглэл	-	-	-	-	-	-
5.2. ҮАБЗ-ийн зөвлөмж	8	5	3	-	-	88.7
6. Засгийн газрын тогтоол	37	20	15	1	1	83.2
7. Ерөнхий сайдын захирамж	-	-	-	-	-	-
8. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	48	35	12	1	-	91.0
9. Засгийн газрын албан даалгавар	5	5	-	-	-	100.0
<b>Нийт</b>	<b>177</b>	<b>110</b>	<b>58</b>	<b>6</b>	<b>3</b>	<b>86.1</b>
<b>Үнэлгээнд эзлэх хувь</b>	<b>100.0</b>	<b>62.2</b>	<b>32.8</b>	<b>3.4</b>	<b>1.7</b>	

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй 6, хэрэгжээгүй 3 арга хэмжээ тус бүрийг хяналтад авч, гүйцэтгэл үр дүнг сайжруулах шаардлагатай.

### 3.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан тус аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 4 бодлого, 17 арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэж, 85.9 хувиар үнэлэв. Нийт арга хэмжээний 29.4 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 64.7 хувь тодорхой үр дүнд хүрсэн, 5.9 хувь эрчимжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 оны хэрэгжилтийн үнэлгээ

Хөгжлийн бодлого	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Нийт	Дундаж үнэлгээ %/
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй		
1. Эдийн засгийн бодлого	-	4	1	-	5	70.0
2. Засаглалын бодлого	3	-	-	-	3	100.0
3. Ногоон хөгжлийн бодлого	2	1	-	-	3	96.7
4. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	-	6	-	-	6	86.7
<b>Нийт</b>	<b>5</b>	<b>11</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>17</b>	<b>85.9</b>
<b>Үнэлгээнд эзлэх хувь</b>	<b>29.4</b>	<b>64.7</b>	<b>5.9</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>	<b>-</b>

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

### 3.3. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ<sup>1</sup>

Орхон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 34 зорилтын хүрээнд 164 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 2023 оны хэрэгжилт 89.9 хувь байна.

Хүснэгт 3. Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ

№	Үндсэн чиглэл	Зорилт	Арга хэмжээ	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)				Дундаж үнэлгээ %/
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	3	9	6	3	-	-	96.7
2	Эрүүл, бүтээлч, хөгжих тэмүүлэлтэй -Эрдэнэт	5	32	18	13	1	-	91.6

<sup>1</sup> Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7 дугаар хавсралтад заасны дагуу Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын жилийн үйл ажиллагааны үнэлгээнд Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн үнэлгээ ороогүй болно.



3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	28	24	4	-	-	96.4
4	Тогтвортой засаглал-Эрдэнэт хүч	4	15	7	6	2	-	84.0
5	Ногоон-Эрдэнэт хот	3	18	11	7	-	-	94.2
6	Ногоон хөгжил	4	17	8	7	2	-	84.1
7	Аюулгүй, амар тайван-Эрдэнэт хот	3	16	11	5	-	-	95.8
8	Тогтвортой хөгжил-Эрдэнэт хот	6	29	15	8	4	2	80.0
<b>Нийт</b>		<b>34</b>	<b>164</b>	<b>100</b>	<b>53</b>	<b>9</b>	<b>2</b>	<b>89.9</b>
<b>Үнэлгээнд үзлэх хувь</b>				<b>61.0</b>	<b>32.3</b>	<b>5.5</b>	<b>1.2</b>	

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам

### 3.4.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2023 онд 8 бодлогын хүрээнд 235 арга хэмжээ хэрэгжүүлж, нийт арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 89.9 хувь байна. Нийт арга хэмжээний 141 арга хэмжээ “үр дүнтэй”, 75 арга хэмжээ “тодорхой үр дүнд хүрсэн”, 15 арга хэмжээ “эрчимжүүлэх шаардлагатай”, 4 арга хэмжээ “үр дүнгүй” хэрэгжсэн байна.

Хүснэгт 4.Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ

№	Хэрэгжүүлсэн бодлого	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)			Үр дүнтэй	Нийт арга хэмжээ	Дундаж үнэлгээ (%)
		Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай			
1	Эрүүл мэнд, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн бодлого	25	9	1	-	35	94.9
2	Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж, гэр бүл, хүүхэд, залуучуудын бодлого	14	8	2	-	24	91.9
3	Боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжил	32	11	2	-	45	93.3
4	Эрүүл хүнс, цэвэр орчин, ногоон хөгжил	19	14	2	1	36	86.6
5	Дэд бүтцийн хөгжил	16	15	6	2	39	80.3
6	Аялал жуулчлалын бодлого	2	3	1	-	6	86.7
7	Үйлдвэрлэл, эдийн засгийн хөгжил	16	4	1	-	21	94.8
8	Найдвартай засаглал	17	11	-	1	29	91.3
<b>Нийт дүн</b>		<b>141</b>	<b>75</b>	<b>15</b>	<b>4</b>	<b>235</b>	<b>89.9</b>
<b>Үнэлгээнд эзлэх хувь</b>		<b>60.0</b>	<b>31.9</b>	<b>6.4</b>	<b>1.7</b>	<b>-</b>	<b>-</b>

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Тус аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг үр дүнтэй, бүрэн хэрэгжүүлэхэд дараах арга хэмжээг 2024 онд эрчимжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал:

- Залуучуудын ордныг түшиглэн “Залуу зохион бүтээгчдийн төв” байгуулах;
- “Багш” хөтөлбөрийн хүрээнд бүх шатны боловсролын байгууллагын багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй барилга, гэрэлтүүлэг шинээр барих /Нарны болон салхины эрчим хүч/;
- Хаврын хүнсний улирлын нөөц бүрдүүлэх зорилгоор махны нөөц бүрдүүлэх;
- Нарны эрчим хүчээр халдаг халаалтын систем нэвтрүүлэх төсөл боловсруулж хэрэгжүүлэх;
- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах бэлтгэл ажлыг хангаж зургийн даалгаварт санал өгөх орон нутгийн ажлын хэсгийг байгуулах;
- Хотын гэр хорооллын цахилгааны эх үүсвэрийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор Эрдэнэ багийн хабитатын хэсэгт 35кВ-ын ЦДАШ, 35/6 кВ-ын дэд станц шинээр барих;

- Барилга байгууламжийн ашиглалтын төлөв байдалд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, паспортжуулах ажлыг үе шаттай зохион байгуулах;
- “Эрдэнэт хотын гамшигт тэсвэртэй байдал” төслийн хүрээнд үерийн сувгийг үе шаттай барих;
- Хотын доторх чиглэлийн НЗ тээвэр, сурагчдын автобусны үйлчилгээнд шаардагдах зогсоол, сүүдрэвч барих;
- Зочид буудал, жуулчны баазуудын үйлчилгээний чанар, стандартыг мөрдүүлэх;
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийг дэмжин ажиллах;
- Архивын байр барих асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх.

### 3.5.Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Орхон аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан 8 бодлого, 181 арга хэмжээний хэрэгжилтийг хянан үзэж, 85.5 хувиар үнэлэв. Нийт арга хэмжээний 66.3 хувь нь үр дүнтэй хэрэгжсэн, 19.3 хувь тодорхой үр дүнд хүрсэн, 9.9 хувь эрчимжүүлэх шаардлагатай, 4.4 хувь үр дүнгүй хэрэгжсэн байна.

Хүснэгт 5. Хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ /хөгжлийн бодлогоор/

Хөгжлийн бодлого	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)			Үр дүнгүй	Нийт	Дундаж үнэлгээ %/
	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай			
1. Үндэсний нэгдмэл үнэт зүйл	4	3	-	1	8	78.8
2. Эрүүл, бүтээлч, хөгжих тэмүүлэлтэй-эрдэнэт хүн	34	6	8	1	49	85.3
3. Амьдралын чанар ба дундаж давхарга	18	6	2	-	26	91.2
4. Эдийн засаг	8	6	4	-	18	80.4
5. Тогтвортой засаглал-эрдэнэт хүч	10	1	1	-	12	91.7
6. Ногоон-эрдэнэт хот	14	1	-	-	15	98.0
7. Амар тайван, аюулгүй хот	10	1	-	1	12	91.6
8. Тогтвортой хөгжил-эрдэнэт хот	22	11	3	5	41	77.6
<b>Нийт</b>	<b>120</b>	<b>35</b>	<b>18</b>	<b>8</b>	<b>181</b>	<b>85.5</b>
<b>Үнэлгээнд эзлэх хувь</b>	<b>66.3</b>	<b>19.3</b>	<b>9.9</b>	<b>4.4</b>	<b>100.0</b>	<b>-</b>

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Төлөвлөгөөнд тусгагдсан дараах арга хэмжээ төсөв, санхүүжилт шийдвэрлэгдээгүй, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг бүрэн, зөв тайлагнаагүй зэргээс шалтгаалан “үр дүнгүй” үнэлэгдсэн байна:

- Наран багийн соёлын төвийн барилгын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн үргэлжлүүлэх;
- Согоот багийн сургуулийн өргөтгөлийн суурийг буулгах;
- Хотын камержуулалтыг нэмэгдүүлж, Шуурхай удирдлагын төвтэй холбох;
- Эрдэнэт хотын гудамж, талбайн нэр, эд хөрөнгийн хаягжуулалтын зургийг боловсруулж батлуулах, иргэд, олон нийтэд сурталчилж, зохион байгуулах;
- Гэр хорооллын багуудад “Миний гудамж-Бидний гэр” төслийн төвлөрсөн шугам барих ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- Орон сууцны хорооллын багуудад “Миний орц-Бидний байшин” төслийг үе шаттайгаар хэрэгжүүлэх;
- 9-р цэг хүртэл Ду700мм-ийн 3.5 км дулааны төв шугамыг шинээр барих;
- Хотын гэр хорооллын цахилгааны эх үүсвэрийн найдвартай ажиллагааг хангах.
-



### 3.6. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ

Орхон аймгийн 2023 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтийг Үндэсний статистикийн хорооны Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn), Байгаль орчин, аялал жуулчлал яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв зэрэг байгууллагын цахим хуудсанд байршуулсан мэдээлэлтэй тулган хянаж, зөрүүтэй байдлыг харгалзан үнэлгээг бууруулж, 98.5 хувиар үнэлэв.

## ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 4.1. Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийн үнэлгээ

Аймгийн Засаг даргын 2023 онд Засгийн газрын гишүүдтэй байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний биелэлтийн дундаж 88.9 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн”, өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад, 1.9 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 6. Засгийн газрын гишүүдтэй байгуулсан гэрээний биелэлт (хувиар)

Засгийн газрын гишүүн	Биелэлтийн хувь	Засгийн газрын гишүүн	Биелэлтийн хувь
1. Эдийн засаг, хөгжлийн сайд	97.1	9. Зам, тээврийн хөгжлийн сайд	95.0
2. Гадаад харилцааны сайд	82.7	10. Соёлын сайд	91.9
3. Сангийн сайд	93.2	11. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд	79.4
4. Хууль зүй, дотоод хэргийн сайд	96.6	12. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	86.6
5. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	94.9	13. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	77.5
6. Батлан хамгаалахын сайд	99.2	14. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	94.1
7. Барилга, хот байгуулалтын сайд	94.3	15. Эрчим хүчний сайд	89.7
8. Боловсрол, шинжлэх ухааны сайд	82.2	16. Эрүүл мэндийн сайд	67.3

Эх сурвалж: Төрийн захиргааны төв байгууллага

Сайд нартай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс үзэхэд, дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна. Тухайлбал:

- Барилга, хот байгуулалтын сайдын хуульд заасан эрхлэх асуудлын чиг үүргээс газрын харилцаа, геодези зураг зүйн чиг үүрэг Монгол Улсын Ерөнхий Сайдын харьяанд шилжсэн тул 2024 оны гэрээний хавсралт төлөвлөгөөнд тусгах эсэхийг холбогдох байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийн болон тус сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлага мэдээллийн системд оруулах ажлыг зохион байгуулж, тус сангийн үйл ажиллагаанд иргэд, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлж ажиллах нь зүйтэй байна.

### 4.2 Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 67 зорилтын хүрээнд 109 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, 74.2 хувиар үнэлэв.

Хүснэгт 7. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ



№	Үндсэн чиглэл	Зорилт	Арга хэмжээ	Үнэлгээ (арга хэмжээний тоогоор)					Дундаж үнэлгээ (%)	
				Үр дүнтэй 100.0	Тодорхой үр дүнд хүрсэн 90.0	70.0	Эрчимжүүлэх шаардлагатай 50.0	30.0		Үр дүнгүй 0.0
1	Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийн тухайн жилийн зорилтыг хэрэгжүүлэхэд хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулах, засаг даргыг удирдлага төлөвлөлт, хяналт зохицуулалтын шаардлагатай зөвлөгөө үйлчилгээгээр хангах замаар засаг даргаас үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх	3	9	-	6	1	2	-	-	78.9
2	Аймгийн ЗДТГ-ын хэвийн үйл ажиллагааг хангах	1	2	-	-	2	-	-	-	70.0
3	Аймгийн нийгмийн салбарын бодлого, төлөвлөлтийг боловсруулан тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхийн зэрэгцээ биелэлтэд нь хяналт тавьж ажиллах	22	26	с	10	4	8	4	-	65.4
4	Аймгийн эдийн засгийн хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангах	2	10	2	-	4	2	1	1	61.0
5	Байгаль орчин, аялал жуулчлалын бодлого, зохицуулалтыг хангах	5	7	2	-	5	-	-	-	78.6
6	Батлан хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2	3	-	3	-	-	-	-	90.0
7	Дэд бүтэц, барилга хот байгуулалт, газар зохион байгуулалтын бодлого зохицуулалтыг хангах	7	11	3	4	4	-	-	-	85.5
8	Засаг дарга, нутгийн захиргааны байгууллага, иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	6	11	-	6	4	-	1	-	77.3
9	Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид захиргааны үйлчилгээ үзүүлэх	6	12	-	7	1	2	1	1	69.2
10	Үйлдвэрлэл, үйлчилгээний бодлого, зохицуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэх	3	5	1	3	1	-	-	-	88.0
11	Хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах	3	4	-	3	-	1	-	-	80.0
12	Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлого зохицуулалтыг хангах	7	9	-	7	-	2	-	-	81.1
<b>Нийт</b>		<b>67</b>	<b>109</b>	<b>8</b>	<b>49</b>	<b>26</b>	<b>17</b>	<b>7</b>	<b>2</b>	<b>74.2</b>

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 24 арга хэмжээ эрчимжүүлэх шаардлагатай, 2 арга хэмжээ үр дүнгүй үнэлэгдсэн байгаад анхаарч, цаашид үйл ажиллагааг оновчтой, бодитой төлөвлөж, хэрэгжүүлэлтийн явцад байнгын хяналт тавих замаар гүйцэтгэл, үр дүнг бүрэн хангаж ажиллах шаардлагатай байна.

#### **4.3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ**

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газраас 2023 онд төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн 2 зорилтын 7 үйл ажиллагааны хэрэгжилтийг хянан үзэж, 67.1 хувиар үнэлэв.

Хүснэгт 8. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, хувиар

Зорилт	Үйл ажиллагаа	Үнэлгээ %/
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх	1.Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	70.0
	2.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	50.0
	3.Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	50.0
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	4.Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	90.0
	5.Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	70.0
	6.Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	70.0
	7.Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	70.0
<b>Дундаж үнэлгээ</b>		<b>67.1</b>

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх зорилтын дундаж 56.7 хувь, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилтын дундаж 75.0 хувь байна. Хоёр зорилтын хүрээнд төлөвлөсөн 7 үйл ажиллагаанаас 2 нь “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн байна.

## ТАВ. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

### 5.1.Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны ил тод байдлыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан үндсэн 5 төрлийн 46 мэдээлэл тус бүрээр хянан үзэж үнэлэхэд, дундаж үнэлгээ 62.1 хувь буюу аймгуудын дундаж үнэлгээнээс 2.0 нэгж хувиар илүү байна. Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад, 6.4 хувиар өссөн байна.

Зураг 1. Мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (мэдээллийн төрлөөр, %)



Цахимаар болон мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгслээр олон нийтэд нээлттэй мэдээлэл зохиох 46 нээлттэй мэдээллээс 36 мэдээлэл 70.0 хувь, 3 мэдээлэл 30.0 хувийн хэрэгжилттэй байна.

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

### 5.2.Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ

Монгол Улсын сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар дунджаар 82 харьяа байгууллагатай ба 2023 онд шилэн дансны цахим нэгдсэн системд нэг байгууллага дунджаар 169 мэдээлэл байршуулахаас 156 мэдээллийг байршуулж, үүнээс 154 мэдээллийг хуулийн хугацаанд, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байх ба шилэн дансны хөтлөлт нийт дунджаар 96.3 хувийн хэрэгжилттэй байна.

Орхон аймгийн Засаг даргын харьяа байгууллагын шилэн данс хөтлөлт 96.3 хувь буюу дундаж үзүүлэлтээс 1.9 нэгж хувиар дээгүүр байна.

Хүснэгт 9. Шилэн данс хөтлөлтийн ерөнхий мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Орхон аймгийн Засаг дарга
Харьяа байгууллагын тоо	82
Байршуулах	162



Нэг байгууллагын шилэн дансанд байршуулах мэдээллийн дундаж тоо	Байршуулсан	156
Мэдээллийг хугацаанд нь байршуулсан эсэх	Хугацаанд нь байршуулсан	154
	Хугацаа хоцроосон	2
<b>Хэрэгжилтийн хувь</b>		<b>96.3</b>

Эх сурвалж: Сангийн яам

### 5.3.Шударга байдлын түвшний үнэлгээ

Орхон аймаг 2023 онд шударга байдлын үнэлгээгээр 100 оноо авахаас 71.2 оноо авч, улсын дунджаас 5.4 оноогоор доогуур үнэлэгдэж, үнэлгээ нь 2021, 2022 оноос буурсан байна.

Зураг 2.Шударга байдлын түвшний үнэлгээ



Эх сурвалж: Авлигатай тэмцэх газрын 2023 оны "Шударга байдлын үнэлгээ" судалгааны тайлан.

## ЗУРГАА. ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АЧ ХОЛБОГДОЛТОЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

### 6.1.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийн үнэлгээ

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг дунджаар 54.2 хувиар үнэлэв. Өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад, 22.3 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 10.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ

№	Үзүүлэлт	Үнэлгээ (хувиар)		Өөрчлөлт (хувиар)
		2023	2022	
1.1	Ногоон байгууламж (Мод тарих)	94.0	94.3	(0.3)
1.2	Цахим шилжилт	58.2	87.0	(28.8)
1.3	Хог хаягдлын менежмент	10.46	48.2	(37.7)
	<b>Дундаж</b>	<b>54.2</b>	<b>76.5</b>	<b>(22.3)</b>

Эх сурвалж: ЦХХХЯ, БОАЖЯ

## ДОЛОО. ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу тус аймгийн бодлогын баримт бичгийн болон хууль тогтоомж, бодлого шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын 2023 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, нэгтгэн дүгнэв.

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дундаж 89.2 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж 76.7 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дундаж 76.5 хувь, Монгол Улсын

хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилт 54.2 хувь, ерөнхий үнэлгээ 79.53 хувь байна.

Хүснэгт 11. Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны үнэлгээний дүн

№	Үзүүлэлт	Хэрэгжилтийн хувь	
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	86.1
		Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	85.9
		Орхон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	89.9
		Орхон аймгийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилт	85.5
		Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	98.5
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	Засгийн газрын гишүүн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт	88.9
		Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	74.2
		Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	67.1
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	Байгууллагын ил тод байдал	62.1
		Шилэн дансны хөтлөлт	96.3
		Шударга байдлын түвшин	71.2
4	Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэл	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	54.2
<b>Оноо</b>		<b>3.98</b>	
<b>Ерөнхий үнэлгээ</b>		<b>79.53</b>	

Эх сурвалж: Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ өмнөх оны дүнгээс 1.19 нэгж хувиар өссөн ба бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дундаж 8.2 нэгж хувиар, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээний дундаж 4.1 нэгж хувиар тус тус өссөн бол байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж 2.4 нэгж хувиар, Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилт 22.3 нэгж хувиар тус тус буурсан байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй болон хэрэгжээгүй 9 заалт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт 83 арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй гэж үнэлэгдсэн. Эдгээр арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт хийж, хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах нь зүйтэй байна.

### НАЙМ. ЗӨВЛӨМЖ

Орхон аймгийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн бодлого, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулахтай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг Зөвлөмж болгож байна:

1. Урт, дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан “эрчимжүүлэх шаардлагатай”, “үр дүнгүй” үнэлэгдсэн зорилго, зорилт, арга хэмжээ, хууль



тогтоомж, тогтоол шийдвэрээс “хэрэгжилт хангалтгүй”, “хэрэгжээгүй” заалтуудыг 2024 онд үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд зохион байгуулалтыг сайжруулах, хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавих замаар байгууллага, албан тушаалтны ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг ирүүлэх;

2. Хөгжлийн бодлогын дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан салбарын бодлого, зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг Монгол Улсын хөгжлийн үзүүлэлт, Олон улсын байгууллагуудын зөвлөмж болгосон хөгжлийн үзүүлэлт, Үндэсний статистикийн хорооноос гаргадаг салбарын албан ёсны статистикийн үзүүлэлттэй уялдуулан тодорхойлох ажлыг зохион байгуулах;

3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн давхардлын судалгааг гаргаж, хяналтад авах, тайлагнах үйл ажиллагааг сайжруулах саналын хамт 2024 оны 7 дугаар сарын 01-ний дотор [monitoring@ags.gov.mn](mailto:monitoring@ags.gov.mn) хаягаар ирүүлэх;

4. Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр дараах шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг ирүүлэх:

- байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтыг стратеги төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилттой уялдуулсан эсэх, зорилго, зорилтыг хангахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөсөн эсэх;

- зорилт, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлсон эсэх;

- шалгуур үзүүлэлтийн суурь түвшинг бодитой, оновчтой төлөвлөсөн эсэх,

- шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшинг төлөвлөхдөө урт, дунд хугацааны зорилгод хүрэхэд хүлээгдэж буй эерэг өөрчлөлтөд хүрэх өсөлттэй чанарын болон тоон утгыг тодорхойлсон эсэх;

- байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгууллагын түвшний арга хэмжээг төлөвлөсөн эсэх /нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөсөн эсэх/;

- байгууллагын нэгжийн болон нэг албан хаагчийн гүйцэтгэх нэг үр дүнд чиглэсэн, нэг агуулга, ижил шалгуур үзүүлэлт бүхий арга хэмжээг багцалж нэгтгэсэн эсэх;

Энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, дээр дурдсан тайланг нотлох баримтын хамт 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг мэдэгдэж байна.

----- оОо -----

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 18 дугаар тэмдэглэлд:

“19.4.Яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1.2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн ерөнхий үнэлгээгээр өндөр оноо авсан Орхон, Ховд, Хэнтий, Завхан, Увс аймгийн Засаг даргын Тамгын газрыг холбогдох журамд заасны дагуу урамшуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд даалгав;

2.“Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлт”-ийг салбарын болон орон нутгийн хөгжлийн үзүүлэлт, бодлогын хэрэгжилт, үр дүнгийн үнэлгээний асуудалтай уялдуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөлт, тайлагналт, үнэлгээний аргачлалыг боловсронгуй болгох арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР